

ОУИТБС-ын хэрэгжилтийн талаар санал дүгнэлт авах тухай зар

Монгол Улс ОУИТБС-т 2007 онд элссэн. 2018 оны 2-р сард ОУИТБС-ын Удирдах зөвлөл Монгол Улсыг ОУИТБС-ыг хэрэгжүүлэхэд “хангалттай ахиц дэвшил” гаргасан гэж үзсэн.¹ ОУИТБС-ын 2019 оны стандартуудын Монгол Улсын дараагийн Баталгаажуулалтыг² 2022 оны 1-р сарын 1-ээс эхлүүлэхээр хуваарь гаргасан.³

Баталгаажуулалтын журмын дагуу⁴ ОУИТБС-ын Олон улсын нарийн бичгийн дарга нарын газраас ОУИТБС-ын стандартыг хэрэгжүүлэхэд 2018 оны 2-р сараас 2022 оны 1-р сарын хооронд Монгол Улсад гарсан ахиц дэвшлийн талаар оролцогчдын санал дүгнэлтийг авна. Оролцогчид Ида Крөг (ljkgrog@eiti.org), Алекс Горди (AGordy@eiti.org) нарын удирдсан Баталгаажуулалтын багт 2022 оны 1-р сарын 1-ий дотор өөрийн санал дүгнэлтээ өгнө үү.

ОУИТБС-ын стандартаар Засгийн газар, олборлох салбарын компаниуд, иргэний нийгэм ОУИТБС-ыг хэрэгжүүлэхэд бүрэн, идэвхтэй, үр дүн гаргаж оролцохыг шаарддаг. Нарийн бичгийн дарга нарын газраас нэн ялангуяа дараах асуултуудад санал дүгнэлт авахыг эрмэлзэж байна:

1. Засгийн газар, олборлох салбарын компаниуд, иргэний нийгэм ОУИТБС-ыг хэрэгжүүлэхэд бүрэн, идэвхтэй, үр дүн гаргаж оролцож байна уу?
2. Эдгээр бүлгүүдийн аль нэгэнд нь эсвэл тэдгээрийн дэд бүлгүүдэд ОУИТБС-ыг хэрэгжүүлэхэд оролцоход ямар нэг саад бэрхшээл эсвэл саад тотгор гарч байна уу?
3. Монгол Улсад ОУИТБС-ыг хэрэгжүүлэхэд улс төрийн өндөр түвшинд байнга өндрөөр анхаарч байна уу?
4. ОУИТБС-ын Монгол дахь салбар тус улсад олборлох салбарын засаглалын өргөн хүрээний шинэчлэл хийж, үр дүн гаргахад хувь нэмрээ оруулж байна уу?

Олборлох үйлдвэрийн санаачилга оролцоонд холбогдож Нарийн бичгийн дарга нарын газраас дараах асуултад холбогдож санал дүгнэлт авна (1.2-р шаардлага):

5. Газрын тос, байгалийн хий, уул уурхайн компаниуд олон талт оролцогчдын бүлгийн ажилд идэвхтэй оролцож, ОУИТБС-аас хүссэн мэдээллийг өгч, ил тод болгож байна уу?
6. ОУИТБС-д оролцоход компаниудыг түлхсэн, урамшуулсан орчин байна уу?

ОУИТБС дахь иргэний нийгмийн оролцоог ОУИТБС-ын Протоколын дагуу үнэлнэ: Иргэний нийгмийн оролцоо.⁵ Оролцогчид протоколыг дагаж мөрдөхийн төлөө байгаа талаар санал дүгнэлтээ өгнө үү.

[1https://eiti.org/board-decision/2018-14](https://eiti.org/board-decision/2018-14)

[2https://eiti.org/validation](https://eiti.org/validation).

[3https://eiti.org/board-decision/2020-92](https://eiti.org/board-decision/2020-92)

[4https://eiti.org/document/eiti-validation-procedure](https://eiti.org/document/eiti-validation-procedure).

[5https://eiti.org/document/eiti-protocol-participation-of-civil-society](https://eiti.org/document/eiti-protocol-participation-of-civil-society).

Хаяг: Радругата 26, 0151 Осло, Норвеги • www.eiti.org

Протоколыг зөрчсөн талаарх аливаа санал дүгнэлтийг зөрчлийн талаарх мэдээлэл, хэзээ болсон талаарх мэдээлэл, холбогдох этгээдүүд болон ОУИТБС-ын журмын линкийг зааж хамт илгээнэ. Баримт нотолгоо байгаа бол мөн багтаана. Иргэний нийгэмд холбогдох журмын аль заалтыг зөрчсөн гэж үзэж байгаа талаар мөн оролцогчид зааж өгч болно. Хариунд холбогдож хүний нэрийг оруулахгүй бөгөөд нууцална.

Иргэний нийгмийн санаачилга оролцоонд холбогдож Нарийн бичгийн дарга нарын газраас дараах асуултад холбогдож санал дүгнэлт авна:

7. ОУИТБС-ын журамд холбогдож иргэний нийгмийн байгууллагууд олон нийтийн хэлэлцүүлэгт оролцож, мөн ОУИТБС-ын журамд холбогдож үзэл санаагаа ямар нэг хяналт, шахалт, шийтгэлд өртөхгүйгээр илэрхийлэх боломжтой юу?
8. ОУИТБС-ын үйл явцад иргэний нийгмийн байгууллагууд чөлөөтэй оролцох боломжтой юу?
9. ОУИТБС-ын журамд холбогдож иргэний нийгмийн байгууллагын төлөөлөгчид харилцан мэдээлэл солилцож, хамтрах боломжтой юу?
10. ОУИТБС-ын журмыг тодорхойлж, хэрэгжүүлж, хянаж, үнэлэхэд иргэний нийгмийн байгууллагын төлөөлөгчид бүрэн, идэвхтэй, үр нөлөөтэй оролцох боломжтой юу?
11. Иргэний нийгмийн төлөөлөгчид ил тод байдал, байгалийн баялгийн засаглалын талаар чөлөөтэй ярьж, ОУИТБС-т холбогдох олон нийтийн хэлэлцүүлэг хийх боломжтой юу?

Протоколын зорилгоор “иргэний нийгмийн төлөөлөгчид” гэдэгт ОУИТБС-ын үйл явцад ихээхэн оролцсон иргэний нийгмийн төлөөлөгчдийг хамруулах ба үүнд мөн олон талт оролцогчдын бүлгүүдийн гишүүд багтана. “ОУИТБС-ын үйл явц” гэдэгт ОУИТБС-ын гишүүн болоход бэлтгэх; ОТОБ [Олон Талт Оролцогчдын Бүлэг]-ийн уулзалтууд; ОУИТБС-т холбогдох ИНБ [Иргэний Нийгмийн Байгууллага]-ын нутаг дэвсгэрийн уулзалтууд, түүний дотор ОТОБ-ийн төлөөлөгчтэй харилцсан байдал; ОУИТБС-ын тайланд холбогдож баримт бичиг материал боловсруулж эсхүл дүн шинжилгээ хийх; байгалийн баялгийн засаглалд холбогдож үзэл бодлоо илэрхийлэхийг ойлгоно.

Хаяг: Радрусгата 26, 0151 Осло, Норвеги • www.eiti.org